



**ХЭНТИЙ АЙМГИЙН
МӨРӨН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 09 сарын 03 өдөр

Дугаар 1/123

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 59 дүгээр зүйлийн 59.1.1, Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тушаалын хавсралт Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хичээлийн шинэ жилийг тохиолдуулан сумын "Зорилтот бүлэг"-ийн хүүхдүүдийн суралцах нөхцөлийг дэмжих үүднээс шаардлагатай хичээлийн хэрэглэлийн зардалд зориулж 300.000 (гурван зуун мянга) төгрөг-ийг зарцуулсугай.

2.Дээрх зардлыг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Нягтлан бодогч (Б.Нандин-Эрдэнэ)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА

Ц.БАТЦООЖ

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ХАМТ

ОЛНЫ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

№ 05

2024 он 09 сарын 03

Хурал 2024 оны 09 сарын 03 ны өдрийн 14 цагт Засаг даргын өрөөнд 90% ирцтэй хурал эхлэв.

ХЭЛЦЭХ АСУУДАЛ:

Хичээлийн шинэ жилийг тохиолдуулан Зорилтот бүлгийн хүүхдүүдэд суралцах нөхцөлийг хангах үүднээс шаардлагатай хичээлийн хэрэглэлийн зардал гаргах тухай

СОНССОН НЬ:

Ц.Батцоож: Та бүхэндээ энэ өдрийн мэнд хүргэе. Хичээлийн шинэ жилийг тохиолдуулан Зорилтот бүлгийн хүүхдүүдэд суралцах нөхцөлийг хангах үүднээс шаардлагатай хичээлийн хэрэглэлийг жил бүр уламжлал болгон авч өгдөг өө энэхүү хичээлийн хэрэгслийн зардлын талаар өнөөдөр та бүхэнтэйгээ хуралдах гэж байна. Та бүхэн минь санал бодлоо хэлэлцье.

Н.Намжилноров: Энэ үйл ажиллагаа нь уламжлал болсон харин зардал мөнгө хаанаас гарах вэ.

Ж.Дашжамц: Зорилтот бүлгийн хүүхдүүдэд суралцах нөхцөлийг хангах үүднээс шаардлагатай хичээлийн хэрэглэлийг жил бүр гаргаж байх нь зүйтэй гэж бодож байна.

Д.Эрдэнэцэцэг миний хувьд Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргаж болно гэж бодож байна.

Ж.Алтанцэцэг би энэ саналыг дэмжиж байна.

Н.Энхмягмар миний хувьд санал нэг байна

Д.Золзаяа миний хувьд санал нэг байна

Б.Мягмаржав хичээлийн хэрэгсэл ямар ямар хэрэгсэл байх уу нэр тоог нь нярав
Г.Мөнхцэцэг гаргасан байгаа байх аа

Намжилноров: За

гарах зардлыг шийдвэрлэх шаардлагатай байна

Ц.Батцоож: Миний хувьд зардлыг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргая гэсэн бодолтой байна. Засаг даргын нөөц хөрөнгийн зардлыг Засаг даргын зөвлөлөөр хэлэлцүүлж зарцуулах журамтай тул та бүхэн хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье

Ц.Батцоож: Гаргах төсөв байгаа учраас зөвлөлөөс шийдвэр гарвал захирамж гаргаад худалдан авах хичээлийн хэрэгслээ авч болно.

Ж.Дашжамц: бүх зүйл тодорхой байгаа учраас Засаг даргын нөөц хөрөнгөөс холбогдох зардлыг гаргах нь зөв байх.

Бусад гишүүд бүгд саналыг дэмжив.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Засаг даргын зөвлөлийн хуралд оруулсан Засаг даргын саналыг хэлэлцэн зөвлөлийн хуралд оролцсон гишүүдийн 100% ийн саналаар 3000.000 төгрөгийн зардлыг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахаар шийдвэрлэв

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:



Г Энхцэцэг